

Н.Болдмаа

МУИС-ийн Социологи, Нийгмийн ажлын тэнхмийн багш,
Социологийн ухааны доктор (PhD)

МОНГОЛЫН КИНО УРЛАГ БА ХҮЧИРХИЙЛЛИЙН СЭДЭВ

Abstract: Historically, that the Mongol society, including government censorship, referred to violence on the screen is much more tolerant than, for example, to erotica, and even more so - to pornography. In 1930 years the violent scenes they most frequently in detective stories, mystery, crime dramas and melodramas, but the main "carriers" of violence on the screen were the military and so-called "revolutionary history" drama and adventure strip. Mystical stories with horror films were completely removed from the repertoire, and westerns detectives relegated to third or even the fourth plan. Just want to point out that now is difficult to determine exactly how many Mongolian films was delivered in the last 10-15 years.

I did a content analysis of the Mongolian repertoire 2010-2012 for the presence in it of violence (fighting, beatings, killings, summary executions, rape, images of the human deaths due to wars and natural disasters, etc.).

The structure of the paper can be represented as follows. First, we show interrelation between cinematography and society. Then we present the results of sociological research.

Key words: Mongolian cinematography, violence, film, screen creation.

Кино урлаг ба нийгмийн холбоо хамаарал

Кино нь XIX зуунд бий болж, XX зуунд үсрэнгүй хөгжсөн, харьцангуй залуу урлаг юм. Кино нь 1920-иод он хүртэл дуугүй, зөвхөн дүрс нь хөдөлдөг, олон нийтэд үзүүлэхэд дуу оруулагч шаардагддаг, эсвэл дүрснүүдийнхээ завсраар бичиг гаргадаг байв. Кино нь дуутай болсны дараа техникийн дэвшлийн үр дүнд улам хөгжиж, өнгө ялгаж харуулдаг болжээ. Өнөөдөр хар цагаан кино хийгдэх нь тун ховор. Улмаар тусгай зураг авалт, анимаци, компьютер график зэрэг шинэ технологи ашиглан үзэгчдийн сэтгэлд хүрсэн, жинхэнэ юм шиг орчинг бүрдүүлэн харуулж чаддаг болжээ. Ерөнхийдөө уран сайхны кино ба баримтат кино гэж 2 ангилалд хуваагдана. Дээр дурьдсанаар кино нь кино театр зэрэгт гаргахын тулд бүтээгддэг боловч анхнаасаа зурагтаар гаргах зорилгоор, киноны хальс ашиглан хийгддэг бүтээлүүд ч бас бий. Тэдгээрийг телевизийн кино гэж нэрлэх бөгөөд 1960-аад оны Америкт телевизийн нэвтрүүлгийн нэг төрөл болон хөгжиж, вэстэрн кино, гэр бүлийн драмууд олноор бүтээгдэж байв. Түүнчлэн кино театрт гаргалгүйгээр, шууд видео хуурцаг зэрэг медиа руу буулган, худалдаалагдах буюу түрээслэгддэг бүтээлийг видео кино гэж нэрлэнэ. Энэ мэтээр орчин үед бродбанд интернэт зэргийн хөгжлийн улмаас өнөөг хүртэл кино гэж нэрлэгдэж ирсэн зүйлс нь олон янз болон өргөжиж буй. Сүүлийн үед кино нь хальсанд буух биш, CD-ROM, DVD зэрэгт бичигдэх нь олширч байгаа. Тэгвэл манай оронд кино урлаг хэрхэн хөгжсөн талаарх түүхийг авч үзье.

Монголын кино урлаг гэж Монгол улсад бүтээгдсэн киноны талаар өгүүлнэ. Монголын кино урлагийн хөгжил нь XX зууны эхэнд буюу 1910-аад оноос эхэлсэн түүхтэй. 1913 онд Монгол улсын гүн, сайн ноён хан Намнансүрэн нь Оросоос кинонууд авчран Богд Хааны өргөөнд гаргаж байжээ¹¹⁵. Монголд XX зууны 1930-аад оноос кино бүтээгдэж эхэлсэн. Хамгийн анх Монгол хүү нэртэй уран сайхны кино гарч байжээ. 1936 оны 7-н сарын 11-нд гаргасан. Зөвлөлт холбоот улсын (одоогийн ОХУ) уран бүтээлчидтэй хамтарсан анхны уран сайхны кино юм. 2-р найруулагчаар Т.Нацагдорж ажилласан. Харин гол дүрд Н.Цэгмид, Ичинхорлоо,

¹¹⁵ Үндэсний төв архивын кино, гэрэл зураг, дуу авианы баримтын төвийн танилцуулга. 2012.

Ч.Цэвээн тоглож байжээ. Түүнээс хойш өдий хүртэл Монгол кино үйлдвэр 212 уран сайхны кино бүтээсэн бөгөөд хамгийн сүүлд «Хааны сүүлчийн хатан» киног 2000 онд бүтээсэн аж.

Кино урлаг ард түмнийг соён гэгээрүүлэхэд чухал үүрэгтэй юм. Гэтэл 1990-ээд оноос хойш манай нийгэмд хүчирхийллийн талаар нэлээд яригдах болж, энэ нөхцөл байдал монголын кино урлагт нөлөөлөх болсон. Хүчирхийлэл гэдэг хэн нэг нь нөгөөгөө хүч, эрх мэдлээр далайлгаж, эрхшээлдээ оруулах зорилгоор хяналтаа тогтоон, өөрийн хамааралд оруулж буй тэгш бус харилцаа юм. Нийгэмд хүчирхийллийн дараах хэлбэрүүд түгээмэл оршин байдаг. Үүнд: эдийн засгийн, бие махбодийн, сэтгэл зүйн, бэлгийн ба сэтгэл санааны хүчирхийллийг дурдаж болох юм. Хүчирхийлэл нь гэр бүлийн орчин, хорих ба түр саатуулах төв, боловсрол олгох бүх л орчин, ажлын байр, хамт олны хүрээнд гардаг. Хүчирхийллийн хохирогчоос хамааран эмэгтэйчүүдийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийлэл гэж ангилж болох юм¹¹⁶.

Түүхэн явцад монголын нийгэм садар самууныг бодвол хүчирхийлэлтэй холбоотой киног бага туурвин, угаасаа төрөөс уг киног гаргахыг нь дэмждэггүй байсан юм. 1930-аад оны үед Оросын октябрийн хувьсгалын нөлөө Монгол киноны сэдэвт тусгалаа олсон. Дэлгэцийн хүчирхийллийн үндсэн “дамжуулагч” нь цэрэг дайны холбогдолтой кино байлаа. 60 гаруй жилийн турш бүтээсэн 212 уран сайхны киноны 40 нь хувьсгалын сэдэвт түүхэн кинонууд байгаа юм¹¹⁷. Жишээ нь гэхэд монгол кино үйлдвэр 1988 онд «Мандухай цэцэн хатан» киног хийсэн. Уг киноны зохиолыг Ш.Нацагдорж бичиж найруулагчаар нь Б.Балжинням ажилласан байдаг. Дээрээс нь «Хатанбаатар», «Цогт тайж» (1945) зэрэг киног нэрлэж болох юм. Их жанжин Д.Сүхбаатарын тухай голлон өгүүлэх «Өглөө», «Тэмцэл», «Сүхбаатар» (1942) зэрэг киног дурьдаж болно. «Өглөө» киног 1968 онд монгол кино үйлдвэр бүтээж байсан байна. Уг киноны зохиолыг Л.Ванган, Ч.Чимэд нар хамтран бичиж Жигжид найруулагч найруулж байжээ. Түүнээс гурван жилийн дараа буюу 1971 онд уг киноны хоёрдугаар ангийг «Тэмцэл» нэртэйгээр хийсэн байна. Энэ кинонд 1921 оны ардын хувьсгалын тухай өгүүлдэг бөгөөд “хувьсгалын эсэргүү” гэх нэрийн доор олон хүнийг буудан хороож, ард түмний дайсан мэт харуулсан байдаг.

Харин 1980-иад оны үеэс социалист нийгмийн бүтээн байгуулалт, тухайн нийгмийн гурамласан бүтэц бүхий ажилчин анги – хоршоолсон ард – сэхээтний амьдралын хэв маяг, хүмүүсийн хүсэл сонирхол зэрэг сэдвүүдээр киног ихээр бүтээх болсон. Зарим судлаачдын үзэж байгаагаар энэ үеэс кино урлаг юуны өмнө өөрийн сэдэв ба жанраа өөрчлөн, илүү хаалттай буюу хүчирхийлэлтэй холбоотой сэдвээр кино хийх болсон.

“Монгол киноны нэвтэрхий толь”-доо Жийгээ (Ардын жүжигчин Гомбожавын Жигжидсүрэн) найруулагчийн түүхчилснээр 1994 онд манай киночид 40 орчим бүтээл хийсэн нь оргил амжилт байлаа. Бүгдээрээ хальсаар, тухайн үедээ харьцангуй өндөр өртгөөр хийгдсэн кинонууд. Үүнээс хойш кино урлагийн салбар зогсонги байдалд орсон.

Шигтгээ 1. Ц.Ганбат (найруулагч, кино судлаач) ярихдаа 2000-аад оны эхэн үеэс жилд гарах бүтээлийн тоо алгуур алгуураар нэмэгдсээр 2011 онд 50 шахуу бүрэн хэмжээний уран сайхны кино хийгдлээ. Энэ нь кино урлаг хөгжиж байгаагийн тод илрэл юм.

“Тэнгис” кино театрынхны явуулсан “Та ямар жанрын кино үзэх дуртай вэ?” гэсэн асуулгад 35289 үзэгч саналаа өгсний 12226 нь “инээдмийн” гэж хариулсан байна. Хоёрдугаар байрт орсон төрөл нь 9887 саналтай “аймшиг ба адал явдалт”¹¹⁸. 2000 оноос хүчирхийлэл киноны үндсэн сэдвүүдийн нэг болон хүчирхийлэлтэй киноны тоо нэмэгдэх хандлага ажиглагдан, гэмт хэрэг, аймшиг ба адал явдалт киноны жанр илүү хөгжих болсон. Продюсер, “ЗМН” продакшны захирал Г.Цогтгэрэлийн өгүүлснээр кино театрын орлогын 80-90 хувийг сурагчид, оюутнууд оруулдаг.

Социологийн судалгаа

Судлаач миний бие судалгааны явцад сүүлийн 10-15 жилийн хугацаанд хичнээн кино гарсан болохыг олж тогтоох бэрхшээлтэй байв. Ийм учраас би Үндэсний төв архивын кино, гэрэл зураг, дуу авианы баримтын төвийн материалууд, 2010-2012 онд “Өргөө – I, II” болон “Тэнгис”, “Соёмбо” кино театруудаас гарсан кино танилцуулга, “Үндэстний тойм” сэтгүүл дээр

¹¹⁶ Болдмаа Н. Социально-историческая обусловленность повседневного насилия в семье (на примере российских и монгольских семей). УБ.: Соёмбо принтинг, 2004. 33-36.

¹¹⁷ Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын төвийн архивын материал. 2012.

¹¹⁸ “Үндэстний Тойм” сэтгүүл. №45(93).

контент-анализ хийсэн юм. Судалгааны зорилго 2010-2012 онуудад бүтээгдсэн кинонуудын агуулга хэр хүчирхийллийн (зодоон, аллага, цаазлах, бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэг, гэмт халдлага, дайн амь үрэгдсэн хүний дүр төрх, аваар ба гэнэтийн гай зовлон г.м.) дүрслэлтэй холбоотой байгааг олж тогтоох явдал юм.

Хүснэгт 1.

2010.01-2012.10 сар хүртэл бүтээгдсэн монгол кинонууд дахь хүчирхийллийн дүрслэл

Он	Киноны тоо	Хүчирхийллийн зураглалтай холбоотой монгол киноны тоо	Хүчирхийллийн зураглалтай холбоотой монгол киноны тоо (%)
2010	27	11	40,7
2011	41	30	73,1
2012.10 сар хүртэл	19	10	52,6
Нийт	87	51	58,6

Хүснэгт 1-ээс харахад 2011 онд харьцангуй олон кино үзэгчдийн хүртээл болсон бол 2011 оныг 2012 онтой харьцуулахад кино бүтээлийн тоо буурсан нь УИХ-ын сонгууль болсонтой холбон тайлбарлаж болох юм. 2010, 2011 ба 2012 онуудад бүтээгдсэн кинонуудын бараг тал хувь нь хүчирхийллийн зураглалыг гаргасан байна.

Хүснэгт 1-т 2011 онд 41 кино бүтээснээс 30 нь хүчирхийллийн дүрслэлтэй байгаа нь хэд хэдэн шалтгаантай гэж үзэж байна.

1. Монголчууд зодоон, аллага, гэмт хэрэг, хүчирхийллийн зураглалтай кино үзэх хэрэгцээ шаардлага байна.
2. Хүн төрөлхтөний амьдралын салшгүй нэг хэсэг нь хүчирхийлэл, түүнийг кино урлагаар дамжуулан дүрслэн гаргаж байна.

Монголын кино урлаг дараах жанр буюу төрлөөр дэлгэцийн бүтээл туурвих нь түгээмэл байна. Үүнд: эмгэнэлт, адал явдалт, инээдмийн, хүчирхийллийн, аймшгийн, түүхэн г.м.

Хүснэгт 2.

2010.01-2012.10 сар хүртэл бүтээгдсэн хүчирхийллийн дүрслэлтэй холбоотой монгол кинонууд

Он	Хүчирхийллийн зураглалтай холбоотой монгол киноны нэр
2010	Татар ажиллагаа, Хархны өгөөш, 7сарын 1, Зүүдний үргэлжлэл, Дэв, Хайрлахсандаа Хайрын рекорд, Намрын синдром, Үлгэрийн хайр, Амилсан хайр г.м.
2011	Давалгаа, Орхидос, Төрийн дайсан, Цусны үнэр, Solo, Амьдрах тасалбар, Нууц ажиллагаа, Үл таних эмэгтэй, Помогите нам -2, Сексийн эрх чөлөө, Франц үнсэлт, Бодлын хулгайч, Хайр харуусал, Төрийн дайсан, Учиртай гурав, Тусгай салаа хоёр – 2, Цахирмаа, Рашаантын 18, Цасан охин, Би чамд хайртай 2, Бөртэ чоно, Чингис хаан, Сайн муу хэрцгий г.м.
2012.10 сар	Долоон бурхан од харавдаггүй, Арван ес, Орлон тоглогч, Помогите нам - 3, Big fish, Дурлалын сум, Нар сарны зааг, Худалч залуу, Жексон амьд, Аравт г.м.

Хүснэгт 2-оос харахад дээр дурдсан хүчирхийллийн дүрслэлтэй кинонууд кинотеатруудад хамгийн их өндөр үнэлгээтэй болон их үзэгчтэй байсан нь яах аргагүй судлаачдын анхаарлыг зүй ёсоор татаж байна.

Хүчирхийлэл – энэ нь биеийн хүчийг ашиглах эсвэл өвтгөх, гэмтээх болон үхэлд хүргэх зорилготой биеийн хүчний давамгайл байдлаа ашигладаг арга хэрэгсэл юм. Монголын кино урлагт энэ сэдэв нээлттэй, түүний янз бүрийн хэлбэрүүдийг гаргаж байна. Кинонуудын баатруудын үг хэллэгт хүртэл эрт дээр үеэс бидний өвөг эцэг хэлэхийг цээрлэдэг байсан харгис шинжийн дараах үгүүд болох “үхэл”, “аллага”, “алах”, “дайн”, “дайсан”, “буудах”, “хороох” зэргийг олон дахин давтамжтай байдлаар хэлдэг. Монголын нийгмийн хөгжлийг яах аргагүй хэвлэл мэдээлэл харилцааны хэрэгслийн үсрэнгүй хөгжилтэй холбож ярих нь зүйн хэрэг. Айл болгон гэртээ кабелийн телевизийн олон сувгуудаар гарч буй киног ямар ч хяналтгүй хүлээн аван өглөөнөөс шөнө хүртэл, балчир хүүхдээс өтөл насны ямар ч хүмүүс үзэх боломжтой болсон нь яах аргагүй анхаарлах татахуйц асуудал билээ.

Бид өөрийн хийсэн судалгааны үндсэн дээр хүчирхийллийн агуулгатай монгол кинонуудыг дараах төрлүүдэд ангилж болох юм.

1. Дайн ба олон нийтийн хүчирхийлэл – “Аравт” уран сайхны кино Чингис хаан гэж ямар хүн байсан, яаж дэлхийг байлдан дагуулсан, энэхүү агуу үйлсийн амин судас, гол хөшүүрэг нь болсон эгэл жирийн цэрэг эрс хэрхэн амьдарч, хооллож, хоорондоо нөхөрлөж, ялахын ид хав болон ялагдахын гуниг зовлонг харуулдаг. “Долоон бурхан харвадаггүй” уран сайхны

- кино нь Гамингууд монголчуудыг хэрхэн дарлаж байсан, түүнээс ангижрахын тулд монгол эрс хэрхэн амиа алдаж байгаа талаар үзүүлсэн.
2. *Гэмт халдлагын хүчирхийлэл* – 2008 оны УИХ-ын сонгуультай холбоотой гарсан үймээн самууны талаар “7 сарын 1” уран сайхны кино үзүүлнэ.
 3. *Гэмт хэргийн хүчирхийлэл* – Омголон дэврүүн зангаасаа болж алдсан залуусын өчүүхэн алдаан дээр дөрөөлөн эрх мэдэл бүхий хар санаатай хүмүүс хэрхэн тэднийг ашиглан, өөрсдийн гар хөлөө болгон, гэмт хэргийн ертөнц рүү оруулан, тэдний амьдралд тод хар толбо үлдээж буй тухай, мөн хүнийг хуурч, залилан гэмт хэрэг хийлгүүлж буй талаар энэ кинонд гарна (“Нар сарны зааг”, “Хархны өгөөш”, “Бодлын хулгайч”, “Сайн муу хэрцгий”, “Боолын гэрээ”, “Цахирмаа”).
 4. *Эмэгтэйчүүд ба бэлгийн хүчирхийлэл* – Эмэгтэйчүүдийг зодон танхайрч, хүчирхийллийн золиос болгон, амьдралын үнэ цэнийн хэрхэн алдагдуулж байгаа талаар өгүүлнэ. (“Үл таних эмэгтэй”, “Секс эрх чөлөө”, “Амилсан хайр”, “Боолын гэрээ”, “Орхидос 2”, “650”, “Намрын синдром”)
 5. *Постмодернист хүчирхийлэл* – 1994 оноос монголын кино найруулагчид хүчирхийллийн агуулгатай кино бүтээхийг нэлээд эрмэлзэх болсон нь үзэгчдийн сонирхлыг төрүүлэхийн тулд байсан. Царайлаг авъяаслаг жүжигчин үнэтэй машин жолоодон, үнэтэй ресторанд хоол идэн, хамгийн үнэтэй амралтанд амран, казино тоглон, хүчирхийлэл ба аллага гаран, мөнгөний төлөө юу ч хийхээс буцахгүй талаар гардаг. (“Луйврын хот”, “Жексон амьд”, “Аз ойрхон”, “Сая доллар”, “Хархны өгөөш”, “Рашаантын 18”)
 6. *Адал явдал ба аймшиг* – Хүний амьдрал адал явдлаар дүүрэн, гэхдээ тэр нь хэрхэн там болж буй талаар кино дүрслэн харуулна. (“Цусны үнэр”, “Дэв”, “Цахирмаа”, “Solo”)
 7. *Хүүхдийн хүчирхийлэл* – Бидний гэрэлт ирээдүй болсон хүүхэд хэрхэн хүчирхийллийн золиос болон, амьдралын хар бараан бартаат амьдралыг туулж байгаа талаар өгүүлнэ. (“Орхидос 1”, “Аз ойрхон”, “Чонын алтан шагай”, “Амилсан хайр”, “Зүүдний үргэлжлэл”)
- Судалгааны явцад бидний олж тогтоосноор Улаанбаатарт кино бүтээдэг 1 кино компани, 7 продакшн, 5 фильм, 5 студи, 2 entertainment үйл ажиллагаа явуулдаг байна.

Дүгнэлт

Статистикаас харахад дэлхийд кино үйлдвэрлэлтээрээ Боливи 1 жилд 1000 гаруй кино хийдгээрээ 1-р байр эзэлдэг. Харин бидний сэтгэхүйгээр кино олноор үйлдвэрлэдэг газар болох Америкийн “Hollywood” 1 жилд 100 гаруй кино хийдэг. Манайх 1 жилд хамгийн оргил үе болох 1994, 2011 онуудад 40 гаруй кино хийсэн нь манай оронд кино урлаг эрчимтэй хөгжиж байгаагийн тод илрэл юм.

Бидний хийсэн судалгаанаас харахад кино театруудад гарч буй кинонуудын 50 шахам хувь нь хүчирхийллийн дүрслэлийг харуулдаг байна. Өөрөөр хэлбэл, зодоон, аллага, цаазлах, бэлгийн хүчирхийлэл, гэмт хэрэг, гэмт халдлага, дайнд амь үрэгдсэн хүний дүр төрх, аваар ба гэнэтийн гай зовлон г.м. Тэнгис кино театрын 2011 онд анкетын аргаар хийсэн социологийн судалгаанаас иш татахад кинотеатрын үзэгчдийн 80-90 хувь нь өсвөр насныхан болон оюутан сурагчид байна. Тэдний ихэнх нь инээдмийн, адал явдал ба аймшгийн төрлийн киног үзэх дуртай гэжээ. Мөн зурагтаар өглөөнөөс шөнө хүртэл хүчирхийллийн агуулгатай киног ямар ч хяналтгүй гаргаж байна.

Кино гэдэг хүний сэтгэхүйд нөлөөлөхүйц асар хүчтэй урлаг юм. Тэр дундаа хүүхдийн сэтгэхүйд илүү нөлөөлнө. Хүүхэд өөрийн баатар гэсэн хүнийхээ зан байдал, амьдралын хэв маяг болон үйлдлийг дууриахыг хүсдэг. Өсвөр насны хүүхдүүдийн дунд киногоор харсан зүйлээ бодит амьдралд туршин гэмт хэрэг үйлдэх хандлага гарсаар байгаа талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх болсон. Энэ ч утгаараа кино урлаг – хүчирхийлэл – ирээдүйн бие хүн гурамласан холбоог нухацтай судлах асуудал бидний өмнө гарч байна.

Ном зүй

1. Болдмаа Н. Социально-историческая обусловленность повседневного насилия в семье (на примере российских и монгольских семей). УБ.: Соёмбо принтинг, 2004.
2. Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын төвийн архивын материал. 2012.
3. “Үндэстний Тойм” сэтгүүл. №45(93).
4. “Өргөө”, “Тэнгис”, “Соёмбо” кинотеатруудын танилцуулгууд.